

---

**Магистрын хөтөлбөрийн бүртгэл хэзээ эхлэх вэ? Яаж бүртгүүлэх вэ?**

- 2021 оны 05 дугаар сарын 10-аас 06 дугаар сарын 27-ны өдрийн 18:00 цаг хүртэл цахимаар буюу <http://elselt.mandakh.mn/> хаягаар бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж 15000 төгрөгийг төлсөнөөр таны бүртгэл баталгаажихийг анхаараарай.
- 

**Магистрын хөтөлбөрөөр хэдэн жил сурч төгсөх вэ? Элсэхэд ямар ямар шаардлага хангасан байх ёстой вэ?**

- Магистрын хөтөлбөр нь 1,5- 2 жилийн сургалттай бөгөөд магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг бакалавр зэрэгтэй, /нягтлан бодох бүртгэл, санхүү, банк, эдийн засаг, даатгал, маркетинг, бизнесийн удирдлага, менежмент/ 2.5-аас дээш голч дүнтэй төгссөн байна.
- 

**Магистрын хөтөлбөрөөр суралцагч нь диплом бичихгүй төгсөж болох уу?**

- Болно. Магистрын хөтөлбөр үндсэн 2 хэлбэрээр сургалтаа явуулдаг.
    - a. Мэргэжлийн мастер буюу диплом бичихгүй кредит цуглуулдаг
    - b. Судлаач мастер буюу суурь хичээлээ судлан диплом бичиж, хамгаалж төгсдөг.
- 

**Магистрын хэдэн хөтөлбөрөөр элсэлт авах вэ?**

1. Нягтлан бодох бүртгэл
  2. Санхүү
  3. Банк
  4. Даатгал
  5. Бизнесийн удирдлага
- 

**Сургалтын төлбөрөө хувааж төлөх боломжтой юу?**

- Тиймээ, та сургалтын төлбөрөө хувааж төлөх боломжтой. Элсэлтээ баталгаажуулахад сургалтын төлбөрийн урьдчилгаа төлж, намар хичээл эхлэхээс өмнө 50%-ийг, 2 сарын 01-ээс өмнө та үлдэгдэл төлбөрийг төлөх боломжтой.
- 

**Элсэлтийн шалгалт авдаг уу? Авдаг бол ямар чиглэлээр авах вэ?**

- Мэргэжлийн суурь мэдлэг болон англи хэлний элсэлтийн шалгалт авдаг.
- 

**Шалгалтнаас чөлөөлөгдөх боломж байгаа болов уу?**

- IELTS-ийн 5.0 болон TOEFL-ийн 510-аас дээш оноотой эсвэл гадаадын их сургуулийн бакалаврын зэрэгтэй, дотоодын их, дээд сургуулийг гадаад хэлний чиглэлээр суралцаж төгссөн бол англи хэлний шалгалтаас чөлөөлөгдөнө.
- 

**Магистрын хөтөлбөрт суралцаж буй оюутнуудад зориулсан хөнгөлөлт, тэтгэлэгт хөтөлбөр байдаг уу?**

Магистрын хөтөлбөрт элсэхэд:

- Мандах ИС-ийн төгсөгч бол эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 20%-ийн хөнгөлөлт үзүүлнэ.
  - Бусад сургуулийн төгсөгч нь дараах болзолыг хангасан бол эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгоно. Үүнд:
    1. Бакалаврын голч дүн 3.0-3.49 бол 10%
    2. Бакалаврын голч дүн 3.5-аас дээш бол 15%
  - Бакалаврын хөтөлбөрийг диплом ажил хамгаалж төгссөн бол эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 10%-ийн хөнгөлөлт үзүүлнэ.
  - Элсэгч нь мэргэжсэн нягтлан бодогч бол эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 10%-ийн хөнгөлөлт үзүүлнэ
- 

Мандах Их Сургуулийн **Магистрант, докторантын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын шилдэг нэг илтгэлийг шалгаруулж, тухайн жилийн сургалтын төлбөрийн доорхи хувьтай тэнцэх дүнтэй судалгааны тэтгэлэг олгоно. Үүнд:**

- Магистрантын шилдэг илтгэлд олгох судалгааны тэтгэлэг: 25%
  - Докторантын шилдэг илтгэлд олгох судалгааны тэтгэлэг: 50%
-